



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/372

Булган сум

Хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.6, 7.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн санал санаачилгыг өрнүүлж, эрүүл цэвэр орчинд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Тус арга хэмжээг чанартай зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010480

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 21-ны/ний өдрийн А/32 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг зохион
байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Баярбат (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
газрын дарга)

П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)

Ц.Бүрэнтуяа (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)

Г.Алдармөнх (Соёл, урлагийн газрын дарга)

Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Г.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд
хурандаа)

Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын дарга)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)

Ц.Энхтуяа (Булган сумын Соёлын ордны захирал)

Нарийн бичгийн дарга: Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 21-ны/ний өдрийн А/332 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ УГТАН
“НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” УРИАН ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ**

Үндэслэл: НҮБ-ын Ерөнхий ассамблей “Хүүхдийн эрхийн тунхаглал”-ыг 1959 оны 11 дүгээр сарын 20-нд, “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ыг 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталжээ. Түүнд дэлхийн хамгийн олон буюу 191 орон нэгдэн орсны дотор Монгол Улс 1990 онд 5 дахь орон болон нэгдэн орсон байна. Энэ конвенцын үзэл санаанд нийцүүлэн УИХ-аас “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг 1996 онд баталжээ.

Манай аймгийн хувьд нийт 61943 хүн ам оршин суудгаас 0-17 насны 21039 хүүхэд багачууд байна. Энэ үзүүлэлтээс харахад нийт хүн амын 33.9 хувийг хүүхэд, өсвөр үеийнхэн эзэлж байна.

Зорилго: Хүүхдийг эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн санал санаачилгыг өрнүүлж, эрүүл цэвэр орчинд баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхэд багачуудаа баярлуулах явдал юм.

Хамрах хүрээ, хугацаа: Булган сумын нийт хүүхэд багачуудыг хамруулан 2024 оны 06 сарын 01-ний өдөр “Цогт хунтайжийн талбай”-д тусгай хөтөлбөрийн дагуу, сум орон нутаг, байгууллагын хэмжээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулна.

Зохион байгуулагчид: АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл урлагийн газар, Цагдаагийн газар, Биеийн тамир спортын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Булган сумын ЗДТГ, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Булган сумын Соёлын ордон.

Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл: Энэ жилийн Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалал өдрийг Цогт хунтайжийн талбайд төвлөрүүлэн нэгдсэн зохион байгуулалтаар тэмдэглэн өнгөрүүлж, “Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн”-д 3-4 тоглоом 11:00 – 20:00 цагийн хооронд байнгын ажиллана.

- Баярын арга хэмжээг зохион байгуулах талбайн зураглал схем гаргаж байгууллагуудад тараах (ХГБХХГ, АЗДТГ)
- Талбайн чимэглэл хийж, чимэглэх (БШУГ)
- Үлгэрийн баатруудын маскратууд хийх (БШУГ)
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн теле хөтөлбөр бэлтгэж, олон нийтийн сүлжээнд тавих (ХГБХХГ, сумын нийгмийн ажилтнууд)
- Зураг авхуулах фоно, үлгэрийн баатруудын хамт байршуулах (Булган сумын ЗДТГ)
- Аймаг, сумын Засаг дарга нарыг хамруулан цахим мэндчилгээ бэлтгэн цахимаар түгээх

- Цогт хунтайжийн талбайг 2 удаагийн давтамжтайгаар усаар шүршиж, чийгшүүлэх (Булган сумын ЗДТГ)
- Нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн хөтөлбөр гаргах (СУГ, Булган сумын Соёлын ордон, ХЖТ)
- Масс хүүхдүүдийг хамруулсан “Флаш моб” бүжиг, Найрал дуу бэлтгэх (ХЖТ, БШУГ)
- 16 нас хүрсэн хүүхдүүдэд иргэний үнэмлэх гардуулах “Иргэний андгай өргөх ёслол” арга хэмжээг зохион байгуулах (ХГБХХГ, УБХ)
- Байгууллага бүр гадна орчноо цэвэрлэж, чимэглэх
- 06 сарын 01-ний өдрийг архигүй өдөр байхаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргах (ХЭЗХ)
- Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг гардуулах(ХХҮГ)
- “Номын шидтэнгүүд” маскот зохион байгуулагдах (Нийтийн номын сан)
- Нээлтийн үйл ажиллагаа “Булганхангай хүүхдүүд-2024” урлагийн наадмын шилдэг хүүхдүүдийн тоглолтоор “Цогт хунтайжийн талбай”-д зохион байгуулах (Булган сумын Соёлын ордон, ХЖТ)
- “Ид шидийн орон” хүүхдийн жүжиг тоглох (ХЖТ)
- Хүүхэд, багачуудад зориулсан кино үзвэр (ХГБХХГ)
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын хүүхдүүдэд зориулсан тэмцээн, уралдааны өртөө ажиллуулах (Хаан, Хас, Төрийн банкнууд, Мобиком, Скайтал, G мобайл ХХК-ууд)
- Нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх
- Авто машингүй өдөр арга хэмжээг зохион байгуулж, төв замыг хаан уралдаан тэмцээн зохион байгуулах (ЦГ, БШУГ)
- “Хүүхэд эрхэм хэрэглэгч” хүүхдийн худалдааны гудамж ажиллуулах (Булган сумын ЗДТГ, СХЗХ)
- "Миний нутаг орны домог" гар зургийн уралдааны шилдэг бүтээлүүдийн үзэсгэлэн гаргах (БШУГ)
- Виртуал музей ажиллах (Музей)
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын хаалтын үйл ажиллагаа “Шоу тоглолт” (Булган сумын Соёлын ордон, ХЖТ)
- Ахлах ангийн хүүхдүүдэд зориулсан өсвөрийн загвар зохион бүтээгч, загвар өмсөгчдийн шоу зохион байгуулагдах (БШУГ)
- Хүүхдэд өсвөр үеийнхэнд зориулсан “Open mic” тэмцээн “Сансар – 1” сааданд зохион байгуулагдах (Булган сумын Соёлын ордон)

-----oOo-----